



ДУНДГОВЬ АЙМАГ

ЛУУС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 9 дүгээр сарын 24-ны өдөр

Дугаар 60

Цагаан-Овоо

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН

ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "д", Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн 15 дугаар Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Тус сумын нутаг дэвсгэрт энгийн хог хаягдал үүсгэсний үйлчилгээний хураамж, зайлуулсны үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.
- 2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тарифын дагуу аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэр, үйлчилгээний газар, айл өрхүүдээс хурааж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллахыг сумын Засаг дарга Б.Баттулга/-д/ үүрэг болгосугай.
- 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар тогтоол, 2020 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 59 дүгээр тогтоолыг тус тус хүчингүйд тооцсугай.
- 4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Алдармаа/-д даалгасугай

ДАРГА Д.ЭНХБААТАР